



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 31 өдөр

Дугаар Б/54

Хэрлэн сум

Т.Отгонтуяаг хавсран гүйцэтгэгчээр
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 56 дугаар зүйлийн 56.1, 56.2, 109 дүгээр зүйлийн 109.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хувийн ашиг сонирхлын удирдчилсан мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт хянуулж, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй тул Төмөртөгоогийн Отгонтуяаг 2022 оны 11 дүгээр сарын 01-ээс эхлэн аймгийн Нийтийн номын сангийн захирлын үүргийг хавсран гүйцэтгэгчээр томилсугай.

2.Ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Д.Өнөрцэцэг Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд: Н.Зоригтбаатар Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн
мэргэжилтэн


Ч.Алтанцэцэг Аймгийн Нийтийн номын сангийн
Архив бичиг хэргийн эрхлэгч

3.Т.Отгонтуяад захирлын үүргийг хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлсийг үндсэн цалингийн 40 хувиар тооцож олгохыг Нийтийн номын сангийн Нягтлан бодогчид зөвшөөрсүгэй.

4.Нийтийн номын сангийн захирлын албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Т.Отгонтуяад үүрэг болгосугай.

5.Т.Отгонтуяад томилогдсоноос хойш 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгээ Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Ж.Гантулга)-т гаргаж өгөх үүрэгтэйг сануулсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ